

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА *Мунгал* Ч. МӨНХТУЯА
2024 оны *03* дугаар сарын *07*-ны өдөр

НИСЛЭГИЙН ЯРИАНЫ БИЧЛЭГИЙН СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод Өлгий, Тосонцэнгэл нисэх буудлуудад шинээр суурилуулах 16 сувгийн нислэгийн ярианы бичлэгийн системийн тоног төхөөрөмж (2 иж бүрдэл), программ хангамжийн техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн тоног төхөөрөмжийг нийлүүлж суурилуулна. Үүнд:

- 2.1 Системийн командын интерфейс, программ хангамжийн интерфейс, дэлгэцийн интерфейс нь англи хэл дээр байна.
- 2.2 Техникийн бичиг баримт, танилцуулга, гарын авлага, техникийн тодорхойлолт болон тухайн тоног төхөөрөмжтэй холбогдолтой сертификат нь англи хэл дээр байна.
- 2.3 Бичлэгийн систем нь үндсэн, нөөц серверүүдтэй байх бөгөөд бие биеэсээ үл хамаарсан бие даан ажиллах боломжтой байна.
- 2.4 Бичлэгийн системд хяналт тавих терминал компьютертой байх.
- 2.5 Системийн үйл ажиллагааг хянах, удирдах, тохиргоо хийх, өгөгдлийн архивд хандах хэрэглэгчдийн эрхийг удирдах боломжтой байх.
- 2.6 Серверийн үйлдлийн систем нь лицензтэй Microsoft Windows Server эсвэл Linux үйлдлийн системтэй байна.
- 2.7 Ярианы бичлэгийн системүүд нь ИНЕГ-т одоо ашиглагдаж байгаа дотоод холбооны телефон станц, нислэгийн ярианы дуун холболтын системийн интерфейсүүдийг дэмжин ажилладаг байх.
- 2.8 Бичлэгийн системийн иж бүрдэл тус бүр нь цагийн тохиргоо хийх GPS NTP сервертэй байна. Ярианы бичлэгийн систем болон терминал компьютерууд нь дотоод сүлжээ ашиглан NTP серверээс цагийн тохиргоог автоматаар хийдэг байна.
- 2.9 Системд ашиглагдаж байгаа бүх программ хангамж (Install болон image)-ийг DVD эсвэл нөөц хатуу дискт хадгалсан хэлбэрээр захиалагчид хүлээлгэн өгнө. Тоног төхөөрөмжийн техник ашиглалтын гарын авлага, программ ашиглалтын гарын авлага, угсралт суурилуулалтын гарын авлага зэргийг хавсаргасан байх.
- 2.10 Нийлүүлэгч нь ашиглагч байгууллагад тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн техникийн туслалцааг баталгаат хугацаанд үнэ төлбөргүй үзүүлэх боломжоор хангах.

2.11 Үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ, Техникийн тодорхойлолтыг хангасан нотлох бичиг баримт /үйлдвэрлэгчийн техникийн баримт бичиг, гарын авлага/ ирүүлэх.

3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.1 Орон нутгийн нисэх буудлуудад шинээр суурилуулах нислэгийн ярианы бичлэгийн системийн 16 сувгийн (2 иж бүрдэл) серверийн техникийн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна.

№	Техникийн үзүүлэлт	Утга
Техник хангамжийн үзүүлэлт		
1	Бичлэгийн систем	Аналог 16 сувгийг бичих боломжтой байх. 19 инчийн зогсуурт суурилагдах боломжтой байх.
2	Хатуу диск / Hard disk	<ul style="list-style-type: none"> Сервер тус бүр дуун өгөгдөл хадгалах 500GB эсвэл түүнээс дээш багтаамжтай хатуу дисктэй байх ба 16 сувгийг тасралтгүй бичлэг хийхэд 90 хоног хадгалах боломжтойгоор хатуу дискийг сонгосон байна. Системд хатуу диск нэмэх боломжтой нэмэлт оролттой байх. Бичлэгийн үйлдлийн систем болон бичлэг хадгалах хатуу дискууд нь тусдаа байна.
3	Сүлжээний интерфэйс	10/100 Mbps Ethernet
4	Үйлдлийн систем	Windows server эсвэл Linux лицензтэй үйлдлийн системтэй байх.
5	Audio Encoding & Decoding	A-Law 64kbps, μ -Law 64kbps, ADPCM 32kbps
6	Орчны нөхцөл	<ul style="list-style-type: none"> Ажиллах температур: 0°C - 55°C Хадгалах температур: -20°C - 85°C Чийгшил: 8% - 90%
7	Сувгийн тоо, оролт/гаралтын интерфэйс	16 ширхэг, RJ11 интерфэйстэй байна.
8	Бичлэгийн төрөл, формат	Бичлэгийг PCM, MP3, VOX, WAV форматаар бичих болон экспорт хийх боломжтой байх.
9	Тэжээлийн систем	230AC, 50Hz эсвэл AC to DC хувиргууртай тэжээлийн блоктэй байх
10	Тоног төхөөрөмжийн тэжээлийн залгуур (PDU)	8 оролттой евро стандарт тэжээлийн залгуур байх
11	Кроне блок	Нийт сувгийн тоогоор
Программ хангамжийн үзүүлэлт		
12	Хэрэглэгчийн удирдлага	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчийн мэдээллийг нэмэх, устгах, өөрчлөх боломжтой байх. Систем хэрэглэгчдийн тоог хязгаарладаггүй байх. Хэрэглэгчдийн эрхийг өөр өөр түвшинд тохируулах боломжтой байх.
13	Сувгийн тохиргооны функц	<ul style="list-style-type: none"> Бичлэгийн системийн сувгуудын тоо, үсэг ашиглан нэр өгөх боломжтой байх. Бичлэгийн суваг тус бүрийг бичлэг хийх сувгийн төрлөөс хамаарч тохируулж болдог мөн бүх сувгийг бичих, бичлэг хийхгүй гэх мэт тохиргоог хийх боломжтой байх.
14	Алсын зайнаас тохиргоо хийх функц	<ul style="list-style-type: none"> Бичлэгийн системд сүлжээний орчин ашиглан бүх төрлийн веб хөтөч ашиглан хандаж бүрэн ашиглах боломжтой байх.

		<ul style="list-style-type: none"> • IP хаягийг алсын хандалтаар өөрчлөх боломжтой байх. • Бичлэгийн сервер дээр цаг хугацаа, огнооны өөрчлөлтийг алсын хандалтаар хийх боломжтой байх.
15	Бичлэгийн хайлт хийх функц	<ul style="list-style-type: none"> • Нэг болон олон төрлөөр хайлтыг дэмждэг байх. • Сувгийн дугаар, залгасан дугаар, дуудлага ирсэн дугаар, бичлэг хийх хугацаа, бичлэгийн урт, дуудлагын чиглэл, дуудлагын төрлөөр хайлт хийх боломжтой байх. • Бичлэгийн файлуудыг тоглуулах, татаж авах, устгах боломжтой байх.
16	Бичлэгийн хяналт	<ul style="list-style-type: none"> • Дуун өгөгдлийг бодит хугацаагаар (real-time) хянах, шууд сонсох боломжтой байх. (зөвхөн давуу эрх бүхий хэрэглэгчид ашиглах боломжтой).
17	Системийн ажиллагааны бүртгэл	<ul style="list-style-type: none"> • Хэрэглэгч болон серверийн ажилласан хугацаа, дэлгэрэнгүй мэдээллийг систем ажиллагааны бүртгэлд бүртгэдэг байх.
18	Санах ойг удирдах функц	<ul style="list-style-type: none"> • Хард дискний багтаамж, хүчин чадлыг автоматаар тооцоолдог байх. • Эхний хард диск дүүрэн болсны дараа өгөгдлийг дараагийн диск дээр хадгалдаг байх. • Бүх диск дүүрсэн үед анхааруулах эсвэл мэдээллийг хэсэгчлэн устгадаг байх.
19	Бичлэг нөөцлөлт, архивлалт	<ul style="list-style-type: none"> • Бичлэгийг гадны төхөөрөмжид хуулж авах боломжтой байх.
20	Програм хангамжийн удирдлагын функц	<ul style="list-style-type: none"> • Системийн тохиргоог серверээс эсвэл веб интерфэйсээр хандаж тохируулах боломжтой байх.
21	Анхааруулга дохио өгөх функц	<ul style="list-style-type: none"> • Систем нь анхааруулга дохиолол өгдөг байх. Үүнд: дискийн хэвийн бус ажиллагаа, сувгийн холболтгүй болох, систем хэвийн бус ажиллах, өгөгдлийн сан гэмтэх, урт хугацааны туршид бичлэг хийгдээгүй зэрэг тохиолдлуудад анхааруулга өгдөг функцтай байх.

3.2 Тосонцэнгэл, Арвайхээр нисэх буудлуудад шинээр суурилуулах нислэгийн ярианы бичлэгийн системийн 16 сувгийн (2 иж бүрдэл) дагалдах тоног төхөөрөмж нь доорх шаардлагыг хангасан байна.

№	Техникийн үзүүлэлт	Утга
Терминал компьютер		
1	CPU	13 th Gen Intel® Core™ i3-13100
2	Operating System	Microsoft® Windows 11 licensed
3	Memory	8 GB DDR4
4	Storage	1Tb SATA
5	Network Controller	Integrated Intel® Ethernet 100/1000
6	Monitor	22" LED
7	Keyboard	USB оролттой
8	Mouse	USB оролттой
9	Audio Speakers	External speakers
Сүлжээний салаалагч /Switch/		
10	Стандарт протокол	IEEE 802.3i, IEEE 802.3u, IEEE 802.3ab , IEEE 802.3x
11	Интерфейс	16 порттой. 10/100Mbps RJ45 Ports
12	Тэжээлийн оролт	230VAC, 50/60Hz
13	Хэмжээ	19 инчийн зогсуурт суурилагддаг байх.

GPS NTP сервер		
14	Цаг хүлээн авагч төхөөрөмжийн интерфэйс	GPS цагийн хүлээн авагч нь TCP/IP (10/100 Mbps) протоколоор сервер компьютертэй холбогдох боломжтой байх.
15	GPS антен	Гадна суурилуулах GPS антентай, холбогч кабел нь 30 метрээс багагүй байх.

4. НИЙЛҮҮЛЭХ ТОО ХЭМЖЭЭ

Нислэгийн ярианы бичлэгийн систем нь дараах иж бүрдлээс бүрдэнэ.

№	Нэр төрөл	Нийлүүлэгдэх тоо ширхэг (иж бүрдэл)	Үзүүлэлт, иж бүрдэл хамаарах зүйлс
1	Бичлэгийн системийн сервер	4 ш (2 иж бүрдэл)	3 Техникийн үзүүлэлт хэсэгт заасан шаардлага болон бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрэн хангасан байна.
2	Бичлэгийн системийн дагалдах тоног төхөөрөмж	2 иж бүрдэл	3 Техникийн үзүүлэлт хэсэгт заасан шаардлага болон бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрэн хангасан байна.

5. ХҮЛЭЭН АВАХ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон иж бүрдлийг шалгаж, ажил хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.

Ачааг хүргэх цэг: Иргэний нисэхийн үндэсний төв

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа

Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албаны дарга

Үнэлгээний хорооны дарга:



Г. Баттөгс

Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн

засаг, төлөвлөлтийн газрын ахлах нягтлан бодогч

Үнэлгээний хорооны гишүүн:



Б.Отгонтуул

“ХУД яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн

Үнэлгээний хорооны гишүүн:




Б.Түмэнзаяа

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”

Төрийн бус байгууллагын гишүүн

Үнэлгээний хорооны гишүүн:



Ж.Амарбаясгалан

Иргэний нисэхийн үндэсний төвийн, Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга:



Э. Төмөрхадуур